



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/35

Чингис хот

“Хайртай” төслийг хэрэгжүүлэх ажлыг
зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй “Хайртай” төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн
ахлагч:

Г.Лхагвахатан

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

С.Оюун-Эрдэнэ

-Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхжаргал

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

Б.Баясгалан

-Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын мэргэжилтэн


Нарийн бичгийн
дарга:

Ц.Мөнгөнзул

-Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн

2. “Хайртай” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийг бэлтгэн хүргүүлж, төслийг дэмжиж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР